

№ 181



“ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ” ХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.05.28 № 2/903
танай _____-ны № _____-т

*Б.Огтосморов
Сударма, хашивуулах.
2019.05.28.*

Тендер шалгаруулалтын тухай

Танай газраас зарласан “Таван толгой ордын Цанхийн хэсгийн ашиглалтын хайгуулын өрөмдлөг” нийлүүлэх ЭТТ/201901108 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох гомдлыг “Буман Дриллинг” ХХК-иас тус газарт ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.4-т заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендер шалгаруулалттай холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг, тендер шалгаруулалтын материал авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбоотой тайлбар, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл болон бусад баримт материалыг 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН



С.ЦОГТГЭРЭЛ

